



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Говьсүмбэр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дэргэдэх
“Цөм сүргийн үржлийн төв”-ийн 2015-2016 оны
үйл ажиллагааны үр дүн



Сүмбэр үүлдрийн хонийг өсгөх, цус сэлбэлт хийж удмын сан, генетик нөөцийг хадгалах арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс цаашид оршин тогтноход эрсдэлтэй байдал бий болсон байна.

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Аудитор Б.Дарханбат 2017 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1: Байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, бүтэц зохион байгуулалт оновчтой бус, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, ажиллах орчин нөхцлөөр хангагдаагүй байна. 1.1 Байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. 1.2 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгслээр хангагдаагүй байна. 1.3 Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна. 1.4 Байгууллага материаллаг бааз сууриа бэхжүүлж, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангагдсанаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх, орлого олох боломжтой байна. Бүлэг 2: Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцээгүй хөрөнгө худалдан авч төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан байна. 2.1 Үйл ажиллагааны орлого, зардлыг бодитой төлөвлөж чадаагүй, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна. 2.2 Борлуулалтын орлогыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн бүрдүүлээгүй, орлогыг НББ-ийн тухай хууль, НББОУС-ын дагуу үнэн, зөв бүртгэж тайлагнаагүй байна. 2.3 Байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцээгүй хөрөнгө худалдан авч төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан байна. 2.4 Үнэ тарифыг тооцоо, судалгаанд үндэслэн тогтоох шаардлагатай байна. 2.5 НББ-д тусгасан өр авлага нь тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажаагүй байна.
---	--

Бүлэг 3: Хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, үндсэн хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.

3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

3.2 Өмч, хөрөнгийг хууль журмын дагуу үнэн, зөв бүртгээгүй байна.

3.3 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилоогүй, зарим хөрөнгийн дансанд хуульд заасан хугацаанд тооллого хийгээгүй байна.

Бүлэг 4: Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй, хяналт шалгалтын үр дүнг тооцож зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.

4.1 Байгууллагын удирдлага дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй байна.

4.2 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.

4.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээний 37.5 хувь нь хугацаа хоцорсон мэдээлэл байна.

Дүгнэлт:.....

Зөвлөмж:.....

Холбогдох байгууллагын санал.....

Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар.....

Хавсралтууд.....

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

2. Аудитын зорилт:

Аймгийн ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн 2015-2016 оны үйл ажиллагааны үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн 2015-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын тайлан болон санхүүгийн тайлан, хүний нөөцийн судалгаа, бүртгэл тайлагналтай холбоотой анхан шатны баримтууд, мэдээ судалгаа, холбогдох бусад материалуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын журмыг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны хяналтыг хийж, аудитор Б.Дарханбат төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

Бүлэг 1

Байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, бүтэц зохион байгуулалт оновчтой бус, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, ажиллах орчин нөхцлөөр хангагдаагүй байна.

1.1. Байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 07 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2014 оны А/27 тоот захирамжаар “Сүмбэр хонь” ОНӨҮГ-ыг татан буулгаж, аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газрын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв” болгон зохион байгуулсан байна.

Тус байгууллагын удирдлагыг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлсөн байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлийг “Сүмбэр үүлдрийн хонины удмын сан, генетик нөөцийг хадгалах, тоо толгойг өсгөх, үржлийн ажил үйлчилгээ, бүртгэл, мэдээллийг мэргэжлийн үндсэн дээр гүйцэтгэнэ” гэж тодорхойлсон боловч 2010 онд Халимаг улсаас 1,000 тун үр авчирч цус сэлбэлт явуулснаас хойш цус сэлбэх ажил хийгдээгүй орхигдсон, Сүмбэр үүлдрийн хонины тоо толгой өсөөгүй байна.

Малын тоо толгойг хүснэгтээр харуулбал:

Он	Эхний үлд	Орлого		Зарлага					Эцсийн үлдэгдэл
		Төл	Нас дэвшилт	Борлуул сан	Нас дэвшилт	Зүй бус	Тушаал	Толгой хамгаалалт	
2016	2,007	559	1,043	252	1,043	200	4	105	2,005
2015	1,834	588	1,068	261	1,068	91	3	60	2,007

Хүснэгтээс харахад: 2014 оны эцэст 1,834 толгой мал тоологдож байсан бол 2015 оны эцэст 2,007 толгой, 2016 оны эцэст 2,005 толгой мал тоологдож, малын тоо толгой өсөөгүй байна.

Малыг үүлдэрээр нь харуулбал /2016 оны байдлаар/:

Малын тоо	Сүмбэр үүлдрийн хонь	Эрлийз хонь	Хээлтүүлэгч	Эр хонь
2,005	1,294	495	24	192

Хүснэгтээс харахад: Нийт үржүүлж буй хонины 64.5 хувь нь Сүмбэр, 24.6 хувь нь эрлийз, 1 хувь нь хээлтүүлэгч, 9 хувь нь эр хонь байна.

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14-т “мөхөхөд хүрч буй мал” гэж тооны хувьд хэт цөөрч тухайн үүлдэр, омог, хэвшлийн малын хээлтэгч нь 1,000-д, төрлийн малын хээлтэгч нь 20,000-д хүрэхгүй болсон тохиолдлыг” гэж заасан бөгөөд “Сүмбэр үүлдрийн хонь” нь дээрх тодорхойлолтод багтаж, цаашид оршин тогтноход эрсдэлтэй байдал бий болсон байна.

Иймд байгууллагын үндсэн чиг үүргийн дагуу Сүмбэр үүлдрийн хонийг өсгөх, цус сэлбэлт хийж удмын сан, генетик нөөцийг хадгалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сүмбэр үүлдрийн хонийг өсгөх, тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор АИТХТ-ийн 2010 оны 61 дүгээр тогтоолоор “Сүмбэр хонь” хөтөлбөрийг баталсан байна.

Хөтөлбөрийн зорилгыг “Малчдын бодит орлогыг нэмэгдүүлэн ажлын байраар хангах үндсэн дээр Сүмбэр үүлдрийн хонины удмын санг хамгаалан тогтвортой өсгөж, түүний аж ахуй, биологийн ашигтай шинжийг бататган каракуль арьс, нэхийг элдэж боловсруулан экспортын баримжаатай, өөрийгөө тэтгэдэг санхүүтэй үйлдвэрлэл хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон бөгөөд хөтөлбөрийн 2 дугаар үе шатанд 2015-2019 оныг хамруулж, цэвэр үүлдрийн хонины тоог 2,032, эрлийз хонины тоог 14,267 толгойд хүргэх зорилт дэвшүүлсэн боловч төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын буюу бүх шатны ИТХ-ын бүрэн эрхийг Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1-т “нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, үйлчилгээний хөлсний норматив батлах, малын өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, бэлдмэлийн нөөц бий болгох, энэ хуульд заасан болон бусад зардлыг баталж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих” гэж хуульчлан заасан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2010 оны 61 дүгээр тогтоолд хөтөлбөрийн хэрэгжих хугацааг 2010-2016 он гэж заасан боловч тус тогтоолоор батлагдсан хөтөлбөр 2010-2019 оныг хамран хэрэгжихээр батлагдсан байна.

“Сүмбэр хонь” хөтөлбөрийн хэрэгжилт дээрх тогтоолоор 2016 онд дууссан бөгөөд хэрэгжилтийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Иймд аймгийн ИТХ гаргасан шийдвэрийнхээ биелэлтэнд хяналт тавьж, хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнг тооцох талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2 заалт тусгагдсан бөгөөд хэрэгжилт 50 хувьтай, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 1 заалт тусгагдсан бөгөөд хэрэгжих шатандаа явж байна.

“Цөм сүргийн үржлийн төв” нь 2015-2016 оны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөгөө аймгийн Засаг даргаар батлуулсан бөгөөд 2015 онд 23 үзүүлэлт, 2016 онд 21 үзүүлэлтээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний биелэлт 81.6-86.0 хувьтай дүгнэгджээ.

Стандартчлал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 62 дугаар тогтоолоор “Цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагаанд тавих шаардлага”-ыг баталсан боловч тус төвийн үйл ажиллагаа дээрх стандартын шаардлагад бүрэн нийцээгүй байна.

Тухайлбал: MNS 5818:2007 стандартын 5 дугаар зүйл “Төвийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”, 5.1.1, 5.1.3, 5.3.2, 6 дугаар зүйл “Ажлын байрны эрүүл ахуйн шаардлага”, 6.1, 6.2-т заасан шаардлагуудыг тус тус хангаагүй байна.


Иймд тус төвийн үйл ажиллагаатай холбоотой орон нутгаас баримталж буй бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүд болон “Сүмбэр хонь” хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй, MNS 5818: 2007 стандартын шаардлагад нийцээгүй байгаа тул аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс гаргасан бодлого шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, байгууллагын үйл ажиллагааны стандарт шаардлагыг хангуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгслээр хангагдаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2015 оны А/78 тоот захирамжаар Хүнс хөдөө аж, ахуйн газрын дүрэм бүтэц, орон тоог шинэчлэн баталсан бөгөөд уг бүтцэд “Цөм сүргийн үржлийн төв”-ийн үндсэн ажилчдын орон тоог төвийн захирал, нягтлан бодогч, мал зүйч, нярав-жолооч нийт 4 орон тоотой байхаар баталсан байна.

2014-2016 оны байгууллагын бүтэц зохион байгуулалтыг харуулбал:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц



Дээрх бүтцээс харахад: Аймгийн ИТХ-ын А/27 дугаар тогтоолоор “Цөм сүргийн үржлийн төв”-ийг ХХААГ-ын дэргэд байхаар шийдвэр гарсан боловч ХХААГ-ын дэргэд бус, ХХААГ-ын дотоод зохион байгуулалтын нэгжид хамааруулж, алдаатай схемчилсэн байна.

“Цөм сүргийн үржлийн төв”-ийн 2015-2016 оны орон тоо, цалингийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Батлагдсан орон тоо, цалин сан	2015 он			2016 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин сан		61,800.0	57,224.9	4,575.1	66,549.6	65,035.0	1,514.6-
1	Удирдах	1	1	-	1	1	-
2	Гүйцэтгэх	2	2	-	2	2	-
3	Үйлчлэх	1	1	-	1	2	1
4	Гэрээт /Малчин/	5	5	-	5	5	-
Нийт		9	9	-	9	10	-
Нэг алба хаагчид ногдох жилийн дундаж цалингийн дүн		6,866.7	6,358.3	508.4	7,394.4	7,226.1	168.3

Хүснэгтээс харахад: Нэг албан хаагчийн цалинд жилд дунджаар 6,358.3-7,226.1 мянган төгрөг зарцуулсан бөгөөд 2016 онд батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү ажиллуулсан байна.

Тус төв нь 2015-2016 оны ажилтан албан хаагчидтай холбоотой гарсан тушаалтай танилцахад байгууллагын удирдлагын зүгээс цалин сан, орон тоо баталсан тушаал гаргаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг зөрчсөн байна.

2015-2016 онд давхардсан тоогоор 9 хүнийг нярав болон жолоочоор ажилд, томилж чөлөөлсөн байна. Энэ нь бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулаагүй, ажлын ачааллыг жигд хуваарилаагүй, тогтвор суурьшилтай ажиллуулаагүй, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг, ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангаагүйтэй холбоотой байна.

Иймд байгууллагын удирдлагаас орон тоог оновчтой зохион байгуулж, ажлын ачааллыг жигд хуваарилах, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, ажиллах орчин нөхцлөөр хангаж ажиллах шаардлагатай байна.

1.3 Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.

Тус төв нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ 2015 онд 9, 2016 онд 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.


Аудитаар тус төвийн хүний нөөцийн өнөөгийн байдалд дараах үзүүлэлтүүдээр судалгаа хийлээ. Үүнд:

1. Орон тооны бүтцийг диаграмаар харуулбал:



Хүснэгтээс харахад: 2015-2016 онд тус бүр 9 орон тоотой ажиллахаас 2016 онд 10 орон тоотой ажилласан байна.

2. Ажиллагсдын боловсролын түвшинг графикаар харуулбал:



Нийт ажилчдын 4 буюу 44.4 хувь нь дээд боловсролтой бусад 5 буюу 55.5 хувь бүрэн бус, бүрэн, тусгай дунд боловсролтой байна.


3. Ажиллагсдын мэргэжлийг хүснэгтээр харуулбал:

Мэргэжил	Төрийн удирдлага, улс төр, эрхзүйч	Нягтлан бодогч	Санхүүгийн менежер	Зоо техникч	Малчин	Нийт
Тоо	1	1	1	1	5	9
Хувь	11.1%	11.1%	11.1%	11.1%	55.6	100%

Хүснэгтээс харахад: “Цөм сүргийн үржлийн төв”-ийн ажилчдын 5 буюу 55.6 хувь малчин, 1 буюу 11.6 хувь нь мэргэжлийн буюу зоо техникч мэргэжилтэй байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох “Сүмбэр” үүлдрийн хонины аж ахуйг үр дүнтэй эрхлэх, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, MNS 5818:2007 стандарт заасан ажил үйлчилгээг үзүүлэхэд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.


Мөн тус байгууллагын нягтлан бодогч нь менежмент санхүүгийн чиглэлийн мэргэжилтэй бөгөөд энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.6-д **“мэргэжлийн нягтлан бодогч” гэж их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэргээр төгссөн хүнийг**, 18.3-т **“Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна”** гэсэн хуулийн шаардлагад нийцээгүй байна.

4. Ажиллагсдыг тухайн албанд ажилласан жилээр нь авч үзвэл:



Графикаас харахад: Ажиллагсдын тухайн байгууллагад ажилласан жил нь 1-3 жил байна. Энэ нь тус байгууллагын ажилчид тогтвор суурьшилгүй, тухайн ажлын байранд ажилласан дадлага туршлага хангалтгүй байгааг харуулж байна. Цаашид ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжлийн боловсон хүчнээр хангах шаардлагатай байна.

5. Ажиллагсдыг насны ангилаар нь авч үзвэл:



Графикаас харахад: Нийт ажиллагсдын 44.4 хувь нь 36-45 насны, 22.2 хувь нь 46-55 насны, 22,2 хувь нь 20-25 насны, 11.2 хувь нь 26-35 насны ажиллагсад байна.

Аудитын явцад боловсон хүчин, хүний нөөцийн баримт бичгүүдийн иж бүрдлийг шалгахад ажлын байрны тодорхойлолт байхгүй, ажилчдын хувийн хэргийн бүрдэлт хангалтгүй байна.

Иймд хувийн хэргийн иж бүрдлийг хангах, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын дагуу боловсруулан баталж, мөрдөж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.4 Байгууллага материаллаг бааз сууриа бэхжүүлж, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангагдсанаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх, орлого олох боломжтой байна.

Байгууллагын 2015, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний стратеги зорилт 2.5, 2.6-д “Сүмбэр каракуль хурганы арьс бэлтгэн, зах зээлд борлуулах, бэлтгэсэн арьсыг технологийн дагуу анхан шатны боловсруулалт хийж, 100 хувь борлуулах”-аар төлөвлөсөн боловч 2015 онд 232 арьс хүлээн авч 243 арьсанд анхан шатны боловсруулалт хийлгэн, элдсэн 92, элдээгүй 92 нийт 184 ширхэг арьс борлуулсан байна.

2016 онд арьс элдүүлэх санхүүгийн боломжгүй байсны улмаас 316 ширхэг арьсыг элдүүлээгүй байна. Үүнтэй холбоотойгоор арьсны борлуулалт өмнөх оноос 37 хувь буюу 3,821.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнээс харахад арьсыг технологийн дагуу элдэж, зах зээлд борлуулснаар орлого нэмэгдүүлэх боломжтой байна.

Мөн ноос хяргах, малыг арьсанд бэлтгэх, нядлах зэрэгт орчин үеийн багаж, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т “гадаад, дотоодын хэрэгцээнд бэлтгэгдсэн мал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулах”, 6.3.5-д “цөм сүргийн удам гарваль, ашиг шимийн мэдээллийн сан бий болгох, үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардагдах багаж хэрэгслээр орон нутгийн үйлчилгээний нэгжийг хангах”, MNS 5818:2007 стандартын 5.1.5-д “Төв нь аймгийн болон бүс нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан цөм сүргийг бүрдүүлж, сумдын цөм сүргийн мал сайжруулагчаар ашиглах өсвөр хээлтүүлэгчийг гэрээ, захиалгын дагуу бойжуулан бүртгэл, мэдээллийн сүлжээгээр дамжуулан худалдан борлуулах ажил үйлчилгээг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасны дагуу дээрх ажил, үйлчилгээг эрхэлж орлого олох боломж байгаа боловч мэргэжилтэй боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж дутагдалтай, ажиллах орчин нөхцөл, ажлын байрны хүрэлцээ, хангамж муугаас шалтгаалан уг ажил үйлчилгээг эрхлэх боломж хязгаарлагдмал байна.

Цаашид байгууллагын материаллаг бааз суурийг бэхжүүлж, орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах талаар судалгаа шинжилгээ хийх, бодитой үр дүн гаргах, идэвх санаачлагатай ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Бүлэг 2

Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцээгүй хөрөнгө худалдан авч төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан байна.

2.1. Үйл ажиллагааны орлого, зардлыг бодитой төлөвлөж чадаагүй, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна.

ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн үндсэн үйл ажиллагааны орлого нь дараах орлогуудаас бүрдэж байна. Үүнд:

1. Арьс борлуулсны орлого
2. Мал, махны орлого
3. Ноосны болон дайвар бүтээгдэхүүний орлого

2015-2016 оны төлөвлөсөн ба батлагдсан орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2016 он			2015 он		
		Төлөвлөсөн	Батлагдсан	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Батлагдсан	Гүйцэтгэл
1	Арьсны орлого	9,000.0	11,270.8	6,580.0	5,415.0	5,415.0	10,401.0
2	Мал, махны орлого	18,500.0	19,610.5	10,776.7	31,898.0	39,260.	20,862.6
3	Ноос	444.2	250.8	962.1	735.0	735.0	417.4
	Ноосны урамшуулал			2,212.6			
4	Нэхий	1,100.0					382.0
5	Мах, мал худалдан борлуулсны авлага			3,240.0			
	Нийт	29,044.2	31,132.1	23,771.4	38,048.0	45,410.0	32,063.0

Хүснэгтээс харахад: Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2015 онд 45,410.0 мянга, 2016 онд 31,132.2 мянган төгрөгөөр батлагдаж төлөвлөсөн дүнгээс 7.2-19.3 хувиар нэмэгджээ. Харин гүйцэтгэлээр 2016 онд 23,771.4 мянга, 2015 онд 32,063.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төлөвлөгөөнөөс 23.6-29.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэхдээ зөвхөн өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан бөгөөд зах зээлийн үнэ ханшийн өөрчлөлтийг авч үзээгүй нь орлого төлөвлөлт бодитой бус байгааг харуулж байна. Иймд орлогын төлөвлөлтийг зах зээлийн үнэ ханшны өөрчлөлт, сүргийн эргэлт зэрэгтэй уялдуулан тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.

2015-2016 оны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2016 он			2016 оны Төсвийн гүйцэтгэл	2015 он			2015 оны гүйцэтгэл
		Төсвийн санал	Өмнөх оноос нэмэгдүүлсэн /-/, бууруулсан /+/ ДүнХувь			Төсвийн санал	Өмнөх оноос нэмэгдүүлсэн /-/ /, бууруулсан /+/ ДүнХувь		
			Дүн	Хувь			Дүн	Хувь	
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	66,549.6	9,324.7	16.3	65,035.0	56,478.0	212.0	0.37	57,224.9
2	Ажил олгогчоос төлөх НДШ	7,320.5	1848.5	33.8	7,320.5	6,213.0	24.0	0.37	5,472.0
3	Бараа үйлчилгээний бусад зардал	12,638.0	597.3	5.0	12,226.9	32,029.0	8,321.0	35.0	12,040.5
4	Татаас ба урсгал шилжүүлэг					300.0	100.0	50.0	
НИЙТ ДҮН		86,508.1	11,770.5	15.7	84,582.2	95,020.0	8,657.0	10.0	74,737.0

Хүснэгтээс харахад: Жил бүр үйл ажиллагааны зардлыг 10.0-15.7 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн бөгөөд зардлын өсөлтөд голлон цалин хөлс, НДШ-ийн зардал, тээвэр шатахуун, эм, өвсний зардлуудыг нэмэгдүүлж төлөвлөсөн нь нөлөөлсөн байна.

2.2 Борлуулалтын орлогыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн бүрдүүлээгүй, орлогыг НББ-ийн тухай хууль, НББОУС-ын дагуу үнэн, зөв бүртгэж тайлагнаагүй байна.

ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн 2015-2016 онд бүрдүүлсэн үйл ажиллагааны санхүүжилт болон өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Орлого, санхүүжилтийн эх үүсвэр	2016 он		2015 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсвийн санхүүжилт	55,071.7	55,071.7	42,334.1	42,334.1
Үндсэн үйл ажиллагааны орлого	31,132.2	23,771.4	45,410.0	32,063.0
Орлого, санхүүжилтийн нийт дүн	86,203.9	78,843.1	87,744.1	74,397.1
Нэмэлт санхүүжилт	0	0	0	0
Нийт орлого, санхүүжилтийн дүн	86,203.9	78,843.1	87,744.1	74,397.1

Хүснэгтээс харахад: 2016 онд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө өмнөх оноос 12,737.6 мянган төгрөгөөр буюу 30 хувиар өссөн бол өөрийн орлогын төлөвлөгөө өмнөх оноос 14,277.8 мянган төгрөг буюу 31 хувиар бууруулан төлөвлөсөн байна.

Харин гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд өөрийн орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 2015 онд 13,347.0 мянга, 2016 онд 7,360.8 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн байна.

Өөрийн орлогын бүрдүүлэлтийг орлогын нэр, төрлөөр нь харуулбал:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2016				2015			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Арьс	11,271	6,580	4,691	41.6	5,415	10,401	(4,986)	(92.1)
Мах	19,611	10,777	8,834	45.0	39,260	21,245	18,015	45.9
Ноос, ноосны урамшуулал	251	3,175	(2,924)		735	417	318	43.2
Мал		3,240	(3,240)				-	
Дүн	31,132	23,771	7,361	23.6	45,410	32,063	13,347	29.4

Хүснэгтээс харахад: 2015-2016 онд орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 23.6-29.4 хувиар тасарсан байна. 2015 онд орлогын төлөвлөгөөний биелэлтэд арьс, махны борлуулалт, 2016 онд мах, ноосны борлуулалтын орлого тасарсан нь нөлөөлсөн байна.

2015 онд 458, 2016 онд 247 малыг тус тус худалдан борлуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2015 онд 261, 2016 онд 252 мал худалдан борлуулжээ.

2015 онд худалдан борлуулахаар төлөвлөсөн 458 хонины 53 хувь нь 1 наст хонь байсан бол борлуулсан 261 хонины 5 хувь нь 1 наст хонь байна. 2015-2016 онд зүй бусаар хорогдсон хонины 73.4-79.5 хувийг 1 наст хонь эзэлж байна.

Иймд зүй бус хорогдлын дийлэнх хувийг эзлэж байгаа 1 наст хониноос заазлан орлого бүрдүүлэх нь үр дүнтэй харагдаж байна.

Аудитаар тус төвийн 2015-2016 оны үйл ажиллагааны орлогын бүртгэл, тайлагналтай холбоотой ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Орлогын төлөвлөгөөг 2015 онд 13,347.0 мянга, 2016 онд 7,361.0 мянга, нийт 20,708.0 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн,
- 2015 онд 1,439.0 мянга, 2016 онд 1,000.0 мянга, нийт 2,439.0 мянган төгрөгийн орлогыг харилцах дансанд төвлөрүүлэлгүйгээр кассаас бэлнээр зарцуулж, данс бүртгэлд тусгаагүй,
- 2015 онд “Шивээ-сервис” ХХК-д махны үнийг дур мэдэн бууруулж худалдан борлуулснаас үнийн зөрүүд 3,970.4 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн,
- Малын нас дэвшилт, бүтээгдэхүүний борлуулалтыг НББ-ийн тухай хууль, НББОУС-ын дагуу бүртгээгүй,
- Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа санхүүгийн програм нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын 1-р хавсралтын 2 дугаар зүйлийн 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассатаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг/ түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй /ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, “Үнийн доод хэмжээг шинэчлэн батлах тухай” АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 40 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Иймд байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан бодит тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн орлогыг боломжит хэмжээ, нэр төрлөөр нь төлөвлөн батлуулж, биелэлтийг нь хангаж ажиллах, НББ-д орлогыг нэр төрлөөр нь үнэн зөв бүртгэж тайлагнах, орлогыг кассаас бэлнээр зарцуулахгүй байх, орлогын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.3 Байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцээгүй хөрөнгө худалдан авч төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан байна.

ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-д 2015 онд 87,744.1 мянга, 2016 онд 86,203.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал батлагдаж, 2015 онд 74,737.5 мянга, 2016 онд 84,582.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2015-2016 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2016 он				2015 он			
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	66,549.6	65,035.0	1514.6	2.3	61,800.0	57,224.9	4,575.10	7.4
2	Ажил олгогчоос төлөх НДШ	7,320.5	7,320.5	0	0.0	6,799.1	5,471.9	1,327.20	19.5

3	Хангамж бараа материалын зардал	6,730.7	6,126.6	604.1	9.9	5,309.0	3,577.5	1,731.50	32.6
4	Нормативт зардал	2,220	1,811.1	408.9	22.6	3,621.0	1,976.0	1,645.00	45.4
5	Эд хогшил худалдан авах	346.8	1,253.6	-906.8	72.3	5,480.0	4,240.5	1,239.50	22.6
6	Томиллолт зочны зардал	265.8	265.8	0	0.0	630.0	238.0	392.00	62.2
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	2,770.5	2,769.8	0.7	0.0	3,905.0	2,008.7	1,896.30	48.6
8	Урсгал шилжүүлэг /Тэтгэмж/					200.0	-	200.00	
	НИЙТ	86,203.9	84,582.4	1,621.5	1.9	87,744.1	74,737.5	13,006.60	14.8

Хүснэгтээс харахад: Нийт төсвийн 78.1-86.0 хувийг цалингийн зардал, 14.0-21.9 хувийг бусад зардлууд эзэлж байна. 2015 онд зардлын гүйцэтгэл 85.2 хувь, 2016 онд 98.1 хувьтай байгаа бөгөөд зардлын гүйцэтгэлд орлогын төлөвлөгөө тасарсан нь голлох нөлөө үзүүлж, төлөвлөсөн орлогоо бүрэн бүрдүүлээгүйгээс үйл ажиллагааны зардлыг бүрэн санхүүжүүлж чадаагүй байна.

Аудитаар тус байгууллагын үйл ажиллагааны зардлыг анхан шатны баримт, журналын бүртгэлтэй тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2015-2016 онд 2,439.0 мянган төгрөгийн кассын орлогыг хууль журмын дагуу төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан,
- Малын зарлагыг тулган баталгаажуулахад 2015 онд толгой хамгаалалтаар 57 мал олгосон баримттай боловч данснаас 60 мал хасагдаж, 90.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 толгой малыг илүү зарлагдсан,
- Малын зүй бус хорогдлыг фото зургаар баримтжуулаагүй,
- Үйл ажиллагааны зардлаас байгууллагад нэн шаардлагатай компьютер, принтер зэрэг тоног төхөөрөмжийг бэлтгэх боломжтой байтал байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцээгүй проектор, хөшиг зэрэг хөрөнгийг 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан,
- Тус байгууллага нь төрийн өмчийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа боловч ХХААГ-ын албан байрыг түрээслэх, үнэ төлбөргүй эзэмшүүлэх талаар эд хөрөнгийн харилцааг зохицуулсан ямар нэг гэрээ хэлцэл байгуулаагүй,
- Мөн ХХААГ-ын ажлын байрны 1 өрөөнд үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч гэрээгээр үйлчлэгч ажиллуулж, 2015-2016 онд цалингийн зардалд 4,435.7 мянган төгрөгийг зарцуулсан,
- Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон НБББББ боловсруулж, батлуулж, мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Толгой хамгаалалтаар илүү олгосон 3 малын үнэ 90.0 мянган төгрөгийг холбогдох этгээдээр нь төлүүлж, орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр акт тогтоов.

2.4 Үнэ тарифыг тооцоо, судалгаанд үндэслэн тогтоох шаардлагатай байна.

ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн үндсэн бүтээгдэхүүн мал, мах, арьсны болон хариулга маллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ажил үйлчилгээний үнэ тарифыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-т “Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ” гэж заасныг үндэслэн аймгийн ИТХ-аас дараах байдлаар тогтоосон байна.

- 2013 оны 62 дугаар тогтоолоор “Малын хариулга, арчилгаа, маллагааны болон аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ажил үйлчилгээний үнэлгээний хөлс”
- 2014 оны 22 тоот тогтоолоор “Сүмбэр үүлдрийн хурганы арьс худалдах жишиг үнийн жагсаалт”
- 2014 оны 40 дүгээр тогтоолоор “ЦСҮТ-ийн хонины бүртгэлийн үнэ болон худалдан борлуулах үнийн доод хэмжээ”
- 2016 оны 47 дугаар тогтоолоор “ЦСҮТ-ийн худалдан борлуулах хонины тоо болон үнийн доод хэмжээ”

Дээрх тогтоолоор баталсан үнэ, тарифийг өнөөдрийг хүртэл мөрдөн ажиллаж байна.

Аймгийн ИТХ-д ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн удирдлагын зүгээс 2015 онд 2 удаа, 2016 онд 3 удаа үнэ тарифаа өөрчлүүлэхээр албан бичгээр хүсэлт гаргасан боловч үнийн өөрчлөлтийн талаарх бодит тооцоо судалгаа, үндэслэлийг гаргаж хүргүүлээгүй байна.

Мөн зах зээл дээр махны үнэ ханш өсөх, буурах үед түүнтэй нийцүүлэн үнэ тарифыг тухай бүр шинэчлэн батлуулаагүй байна. Үүнээс шалтгаалан 2015 онд 250 хонийг тус бүрийг 95.0 мянган төгрөгөөр худалдан борлуулах шийдвэртэй байтал, тухайн үеийн 1 кг махны зах зээлийн ханшаар буюу 4.0 мянган төгрөгөөр тооцож, “Шивээ-сервис” ХХК-д худалдан борлуулснаас 3,970.0 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр 1 кг хонины махны дундаж үнэ 2014 онд 6.7 мянга, 2015 онд 4.5 мянга, 2016 онд 5.0 мянган төгрөг байсан бөгөөд 1 кг хонины махны үнэ 2014 оны үнээс 32.8 хувиар хэлбэлзжээ. Иймд худалдан борлуулах махны үнийг тухайн үеийн зах зээлийн үнэ ханшид нийцүүлэн уян хатан тогтоох шаардлагатай байна.

Каракуль хурганы арьсны худалдан авагчдыг авч үзвэл 99.3 хувь нь иргэн, 0.7 хувь нь албан байгууллага байна. Тус байгууллагын үйлдвэрлэж буй арьсны хэмжээ нь үйлдвэрлэлд ашиглах хэмжээнд хүрэхгүй байгаа тул зах зээл дээрх эцсийн хэрэглэгчид нь иргэд байна. Үнэ тарифыг тогтоохдоо бүтээгдэхүүний өртөг дээр нэмэх ашгийн хэмжээг тодорхойлох нь зүйтэй бөгөөд хэрэглэгчдийн худалдан авах чадвар муу байгаа цаг үед борлуулалт буурах, зах зээл хумигдах зэрэг эрсдэл үүсч болзошгүй байна.

Иймд үнэ, тарифыг тогтоохдоо тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж зах зээлийн үнийн хэлбэлзэл болон малын тарга хүч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ зэргийг харгалзан үзэх, үнийг дур мэдэн өөрчлөхгүй байх, тогтоосон үнийг баримталж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.5 НББ-д тусгасан өр авлага нь тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуу байна.

“Цөм сүргийн үржлийн төв”-ийн санхүүгийн тайланд 2016 оны жилийн эцсийн байдлаар 8,206.7 мянган төгрөгийн авлага, 8,227.2 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Тус байгууллагын ашиглаж буй санхүүгийн програм шаардлага хангахгүй байгаагаас борлуулалт хийхдээ зардалд бичиж, тохируулах бичилтээр авлага үүсгэж байгаа нь авлагад бичигдэх дүнг буруу илэрхийлэх эрсдэлтэй байна.

2016 оны жилийн эцсийн тайланд тусгагдсан өр, авлагыг насжилтаар нь харуулбал:
(мянган төгрөгөөр/)

Говьсүмбэр аймгийн ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн 2016 оны жилийн эцсийн авлагын дэлгэрэнгүй									
№	Нэрс	Үүссэн он сар	Нийт мөнгөн дүн	Үүнээс /авлагын насжилт жилээр/				Төлөгдсөн эсэх	Тайлбар
				2013 ба түүнээс өмнөх он	2014 он	2015 он	2016 он		
	НИЙТ АВЛАГА		8,207.0	4,971.0	425.0	1,981.0	720.0		
1	С.Бат-Эрдэнэ	2016.11.10	110.0				110.0	Тийм	Хурганы арьсны үнэ
2	Т.Отгонтөгс	2016.10.28	25.0				25.0	Үгүй	Ажил хүлээлцэхэд гарсан тооцоо
3	Б.Ганболд	2016.07.06	695.0				695.0	Тийм	Төл дутуу боожуулсаны төлбөрийн үлдэгдэл
4	“Шивээ Сервис” ХХК	2015.11.24	1,606.0			1,606.0		Тийм	Махны үнэ
5	Амгаланбаатар	2015.05.04	375.0			375.0		Тийм	Хурганы арьсны үнэ
6	БУСАД АВЛАГА			4,971.0	425.0	-	-		
1	АИХурал	2013 он	5,396	430.0				Үгүй	Тодорхойгүй
2	Сүрэнжав				330.0			Тийм	Хурганы арьсны авлага
3	Бадамханд			50.0				Үгүй	Тодорхойгүй
4	Төмөрчөдөр			50.0				Үгүй	Тодорхойгүй
5	Бямбасүрэн			2,275.0				Үгүй	Мал үхүүлсэний төлбөр
6	Чимэдцэеэ			151.0				Үгүй	Малын ченж
7	Мөнхтогоо			140.0				Үгүй	Тодорхойгүй
8	Т.Оюундэлгэр			720.0				Үгүй	9 хуцтай холбоотой 2013 оны нярав
9	Төмөртоого			95.0				Үгүй	Тодорхойгүй
10	Нуруу нь хугарсан хонь				95.0			Үгүй	Тодорхойгүй
11	Бусад авлага			1,060.0				Үгүй	Тодорхойгүй

Хүснэгтээс харахад: Нийт авлагын 65 хувь буюу 5,396.0 мянган төгрөг нь 2013-2014 онд үүссэн бөгөөд өнөөдрийг хүртэл барагдаагүй байна.

Иймд он дамжин хуримтлагдсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч, эзэн холбогдогчийг тогтоох, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

(мянган төгрөгөөр/)

Говьсүмбэр аймгийн ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв”-ийн 2016 оны жилийн эцсийн өглөгийн дэлгэрэнгүй									
№	Нэрс	Үүссэн огноо	Нийт мөнгөн дүн	Үүнээс /өглөгийн насжилт жилээр/				Төлөгдсөн эсэх	Тайлбар
				2013 ба түүнээс өмнөх он	2014 он	2015 он	2016 он		
	НИЙТ ӨГЛӨГ		8,227.0	-	418.0	4,540.0	3,269.0		
1	НДШ-ийн өглөг		3,185.0		-	1,477.0	1,708.0	Үгүй	
2	ХАОАТ-ийн өглөг		1,068.0		418.0	312.0	337.0	Үгүй	
3	Шунхлай говь ХХК		825.0		-	613.0	212.0	Тийм	Шатахууны үнэ
4	О.Энхбаясгалан Татах хүч		34.0		-	34.0	-	Үгүй	засварын хөлс
5	НИК ХХК	2016.12.20	210.0				210.0	Тийм	Шатахууны үнэ

6	Сансарт Хайрхан ХХК	2016.11.13	202.0				202.0	Тийм	Барааны үнэ
7	Голден Пэйж ХХК	2016.11.11	600.0				600.0	Тийм	Аудитын төлбөр
8	Мастер Додо ХХК	2015.08.01	1,660.0		-	1,660.0	-	Үгүй	Хурганы арьс элдүүлсний хөлс
9	Чойр Өлзий ХХК	2015.10.20	444.0		-	444.0	-	Үгүй	Өвс худалдан авсан төлбөр

Хүснэгтээс харахад: Нийт өглөгийн 51.6 хувь буюу 4,253.0 мянган төгрөг нь орон тоо, цалин сан хэтэрснээс, 15.4 хувь буюу 1,267.0 мянган төгрөг нь төсөв хэтрүүлснээс, 33 хувь буюу 2,704.0 мянган төгрөг нь төлөвлөгдөөгүй зардал гарснаас /арьс элдүүлэх, аудитын төлбөр, өвс худалдан авах/ тус тус үүссэн байна.

Иймд цалин сан, орон тооны хязгаарт багтаан ажиллах, төсөвт зайлшгүй тусгах зардлын тооцоо судалгааг CTCX-ээр хянуулан АИТХ-аар батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Хөрөнгийг хууль журмын дагуу бэлтгэж, үнэн зөв
бvотгэж тайлагнасан эсэх

Бүлэг 3

Хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, үндсэн хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.

3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2013 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу зохион байгуулах худалдан авалт хийгдээгүй байна.

Харин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2015 онд зохиомол хээлтүүлгийн зөөврийн функт 8,301.0 мянга, 2016 онд зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгсэл 5,960.0 мянга, нийт 14,261.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

3.2 Өмч, хөрөнгийг хууль журмын дагуу үнэн, зөв бүртгээгүй байна.

Тус байгууллага нь санхүүгийн тайлан гаргах төсөвт байгууллагын Acoluos 3.0 програмыг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд уг програмын тохиромжгүй байдлаас шалтгаалан малын нас дэвшилтийн бүртгэлийг үнэн зөв бүртгэхгүй байна.

“Цөм сүргийн үржлийн төв” нь 2015 онд 142,708.8 мянга, 2016 онд 154,879.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан бөгөөд 2015 онд 30,911.0 мянга, 2016 онд 31,970.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол тайлант онуудад 24,270.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдаж, 1,300.0 мянган төгрөгийн хөрөнгө актлагдаж, 3,120.0 мянган төгрөгийн хөрөнгө тооллогоор дутагдаж, 5,290.0 мянган төгрөгийн хөрөнгийг малын толгой хамгаалалтаар тус тус олгосон байна.

2015-2016 оны үндсэн хөрөнгийн бүтцийг диаграмаар харуулбал:

2016 оны үндсэн хөрөнгийн бүтэц



2015 оны үндсэн хөрөнгийн бүтэц



Диаграмаас харахад: 2015 онд нийт үндсэн хөрөнгийн 12.0 хувийг барилга байгууламж, 8.0 хувийг тавилга, эд хогшил, 40.0 хувийг машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө 29 хувь, программ хангамж 1.0 хувь, авто тээврийн хэрэгсэл 10 хувийг эзэлж байсан ба 2016 онд нийт үндсэн 11.0 хувийг барилга байгууламж, 7.0 хувийг тавилга, эд хогшил, 39.0 хувийг машин тоног төхөөрөмж, 33.0 хувийг бусад үндсэн хөрөнгө, 1.0 хувийг программ хангамж, 9.0 хувийг авто тээврийн хэрэгсэл эзэлж байгаа нь 2016 онд бусад хөрөнгө буюу 2 наст хонины данс малын нас дэвшилтээр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт хөрөнгийн дүнд эзлэх бусад хөрөнгийн дүн буурсан үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэсэнээс нийт 45,652.0 мянган төгрөгийн хөрөнгө зөрүүтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэгдсэн хөрөнгийг дансдаар нь хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Хөрөнгийн нэр	Үнэ	Бүртгэсэн данс	Бүртгэх данс
Пүү	1,052.0	Аж ахуйн материал	Тоног төхөөрөмж
Хадлангийн трактор	7,800.0	Тоног төхөөрөмж	Авто тээврийн хэрэгсэл
Трактор	36,800.0		
Нийт	45,652.0		

Хүснэгтээс харахад: Аж ахуйн материалын дансанд 1,052.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, машин тоног төхөөрөмжийн дансанд 44,600.0 мянган төгрөгийн автотээврийн хэрэгслийг бүртгэж тайлагнасан нь нягтлан бодогчийн хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.

Иймд данс бүртгэлд буруу бүртгэгдсэн хөрөнгүүдийг дансны ангилалын дагуу үнэн зөв бүртгэж, санхүүгийн тайланд залруулга хийх албан шаардлага өгч, Сангийн сайдын 2016 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ыг мөрдөх, санхүүгийн програмыг шинэчлэн малын нас дэвшилтийг үнэн зөв бүртгэх зөвлөмж хүргүүлэв.

3.3 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилоогүй, зарим хөрөнгийн дансанд хуульд заасан хугацаанд тооллого хийгээгүй байна.

2016 оны жилийн эцсийн тайлангаар бараа материалын 9 дансанд 70,318.9 мянга, үндсэн хөрөнгийн 6 дансанд 154,879.5 мянга, нийт 225,198.4 мянган төгрөгийн бараа материал болон үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

ХХААГ-ын дэргэдэх “Цөм сүргийн үржлийн төв” нь сар бүр цалин бодохын өмнө малын тооллого хийж малчдаар гарын үсэг зуруулан баталгаажуулж байна. Дутсан малыг толгой хамгаалалтаас суутгаж тооцох, толгой хамгаалалтаас хэтэрсэн тохиолдолд цалингаас суутган төлүүлж байна. Мөн 2016 онд толгой хамгаалалтаас илүү хорогдсон 100 хурганы үнэ 3,000.0 мянган төгрөгийг төлүүлж, малчин Н.Эрдэнэбилэгийн дутагдуулсан 131 толгой хонийг төлүүлэхээр Шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлсэн байна.

Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.

- Байгууллагын өмчид бүртгэлтэй хөдөө аж ахуйн трактор нь ХХААГ-ын эзэмшилд байгаа,
- Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих эрх, үүрэг бүхий өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулаагүй,
- Малыг тооцоог сар бүр бодож тооцоо нийлэн баталгаажуулж байгаа боловч бусад хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4-т “Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна”, 70 дугаар зүйлийн 2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих эрх, үүрэг бүхий өмч хамгаалах зөвлөлийг байгуулж, эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд явуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дотоод хяналт үр дүнтэй эсэх

Бүлэг 4

Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй, хяналт шалгалтын үр дүнг тооцож зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.

4.1 Байгууллагын удирдлага дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Тус байгууллагын удирдлага нь хууль журамд заасан дотоод хяналтын үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх

бүхий этгээд тодорхойлно.”, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна” гэснийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Дотоод хяналт хэрэгжээгүйн улмаас 2015-2016 оны кассын орлого 2,439.0 мянган төгрөгийг бэлнээр зарцуулсан, байгууллагын удирдлагаар ажиллаж байсан Т.Отгонтөгс дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байтал 2015 оны 6-7 сард өөртөө тушаал гаргаж 355.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл авсан нь аудитын шалгалтаар илэрч төлбөр тавигдсан байна.

Иймд хууль журмын хэрэгжилтийг ханган, байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.2 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.

Аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас тус төвийн 2014-2016 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтаар 7,426.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж төлбөрийн акт тогтоосон боловч хяналт шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Голден пэйж аудит” ХХК-иас аудит хийж, Сөрөг санал дүгнэлт өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

4.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн 37.5 хувь хугацаа хоцорсон мэдээлэл байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “... дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна”, 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэсэн заалтын үйлчлэх хүрээнд тус байгууллага хамаарч байна.

“Цөм сүргийн үржлийн төв” нь Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан боловч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу 149 мэдээллийг бүрэн оруулахаас 2015 онд 143 мэдээлэл буюу 4 хувь, 2016 онд 56 буюу 37.5 хувь нь хугацаа хоцорч оруулсан мэдээлэл байна.

Иймд Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн оруулж хэвших шаардлагатай бөгөөд мэдээллийг олон удаа хугацаа хоцроож, дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэсний дагуу хариуцлага тооцуулах үндэслэл болохыг анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Аудитын явцад нийт 80,295.1 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс 90.0 мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, 45,652.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 34,553.1 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- Байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, бүтэц зохион байгуулалт оновчтой бус, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай орчин нөхцөл, техник хэрэгслээр хангагдаагүй байна.
- Тус төвийн үйл ажиллагаатай холбоотой орон нутгаас баримталж буй бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүд болон “Сүмбэр хонь” хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй, байгууллагын үйл ажиллагаа MNS 5818: 2007 стандартын шаардлагад нийцээгүйн улмаас Сүмбэр үүлдрийн хонины малын удмын санг хамгаалах, цус сэлбэх ажил хийгдээгүй, малын тоо толгой өсөөгүйгээс “Мөхөхөд хүрч буй мал” гэсэн тодорхойлолтод багтаж байна.
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох “Сүмбэр” үүлдрийн хонины аж ахуйг үр дүнтэй эрхлэх, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, MNS 5818:2007 стандартын дагуу ажил, үйлчилгээг үзүүлэхэд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.
- Байгууллага материаллаг бааз сууриа бэхжүүлж, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангагдсанаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх, орлого олох боломжтой байна.

Бүлэг-2

- Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцээгүй хөрөнгө худалдан авч төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан байна.
- Борлуулалтын орлогыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн бүрдүүлээгүй, орлогыг НББ-ийн тухай хууль, НББОУС-ын дагуу үнэн, зөв бүртгэж тайлагнаагүй байна.
- НББ-д тусгасан өр авлага нь тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажаагүй байна.

Бүлэг-3

- Хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, үндсэн хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.

Бүлэг-4

- Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй, хяналт шалгалтын үр дүнг тооцож зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн 37.5 хувь хугацаа хоцорсон мэдээлэл байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, аймгийн ИТХТ-ийн 2010 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Сүмбэр хонь” хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлэлт, дүгнэлт өгч, АИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн, үр дүнг тооцох

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2 заалт тусгагдсан бөгөөд хэрэгжилт 50 хувьтай байгаа байдалд үнэлэлт дүгнэлт өгөх
2. “Цөм сүргийн үржлийн төв”-ийн үндсэн үйл ажиллагаа нь Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14-т заасан “мөхөхөд хүрч буй мал” тодорхойлолтод багтаж, цаашид оршин тогтноход эрсдэлтэй байдал бий болсон тул Сүмбэр үүлдрийн хонийг өсгөх, цус сэлбэлт хийж удмын сан, генетик нөөцийг хадгалах чиглэлээр бодлогын түвшинд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын Захирал Г.Батбаярт

1. Байгууллагын үндсэн чиг үүргийн дагуу Сүмбэр үүлдрийн хонийг өсгөх, цус сэлбэлт хийж удмын сан, генетик нөөцийг хадгалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
2. Аймгийн ИТХ, Засаг даргад “Сүмбэр хонь” хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан танилцуулах, MNS 5818:2007 стандарт шаардлагыг хангаж ажиллах
3. Байгууллагын орон тоог оновчтой зохион байгуулах, шаардлагатай компьютер тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, ажиллагсдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах
4. Хүний нөөц, боловсон хүчний бодлогыг оновчтой хэрэгжүүлж, ажиллагсдын хувийн хэргийн иж бүрдлийг хангах, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын дагуу боловсруулан баталж, мөрдөн ажиллах
5. Байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан бодит тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн орлогыг боломжит хэмжээ, нэр төрлөөр нь төлөвлөн батлуулж, биелэлтийг нь хангаж ажиллах, НББ-д орлогыг нэр төрлөөр нь үнэн зөв бүртгэж тайлагнах, орлогыг кассаас бэлнээр зарцуулахгүй байх, орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих
6. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах
7. Үнэ, тарифыг шинэчлэн тогтоолгох саналыг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, зах зээлийн үнийн хэлбэлзэл болон малын тарга хүч, хэрэглэгчдийн

- эрэлт хэрэгцээ зэргийг харгалзан үзэх, үнийг дур мэдэн өөрчлөхгүй байх, эрх бүхий байгууллагаас тогтоосон үнийг баримталж ажиллах
8. Он дамжин хуримтлагдсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч, эзэн холбогдогчийг тогтоох, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах, НББ-д тусгасан өр авлагыг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах
 9. Сангийн сайдын 2016 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ыг мөрдөх, санхүүгийн програмыг шинэчлэн малын нас дэвшилтийг үнэн зөв бүртгэж, батлагдсан төсөвт багтаан өр үүсгэхгүй ажиллах
 10. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих эрх, үүрэг бүхий өмч хамгаалах зөвлөлийг байгуулж, эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийж хэвших
 11. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын мөрөөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гарган баталж, хэрэгжилтийг тайлагнаж байх
 12. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах
 13. Аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, хэрэгжилтийг тайлагнах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-аас ирүүлсэн санал:

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЦӨМ СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВ
42017 Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг
УБД: 3214001003, Утас: 70543261

2017-11-20 № 89
төвийн _____-ны № _____-т

Г _____ Г

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагын 2015-2016 оны үйл
ажиллагааны үр дүнд хийгдсэн Гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд нэмэх зүйл үгүй болно.

ЗАХИРАЛ  Г.БАТБАЯР

Б.Хархуйвараг
Авчлалд сайн
Гууль
Авч
21/7/28

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-аас санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.